



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шим ус ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/04/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: С.Оюунжаргал

Утас: 99105481

цахим хаяг: Oyunjargals@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

| | |
|--|--|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 3 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 5 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | 9 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | 12 |
| 4.1 Ерөнхий зүйл | 12 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 13 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 13 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 13 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 14 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 14 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 16 |
| Товчилсон үгийн жагсаалт | |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТУЗ | Төлөөлөн Удирдах зөвлөл |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| ТБОНӨХБАУХА худалдан авах | Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ |
| ХХХС | Ховд хөшөөт хөгжил сан |
| МУЗГ | Монгол улсын Засгийн газар |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ТБОНӨТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль |



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ШИМ УС ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Н.ГАНБАТ ТАНАА

2023.03.15 № 02/94
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шим ус ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шим ус ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орчны бохирдлыг бууруулах төслийн хүрээнд гэр хорооллын 400 айл өрхүүдэд цэвэр, бохир усны шугам сүлжээ холбох болон бусад ажлын 727.8 сая төгрөгийн тендерт шалгарч 541.0 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйг хөгжүүлэх төслийн хүрээнд төвлөрсөн усан хангамж, ариутгах татуургын системийг шинэчлэх, халуун усны үйлчилгээг сэргээн сайжруулах, гэр хороололд амьдрагчдын усан хангамжийг сайжруулах, хуурай хог хаягдлын асуудлыг шийдвэрлэх замаар хүн амын амьдралын нөхцөлийг сайжруулах зорилгоор 1998 онд Азийн хөгжлийн банкнаас авсан урт хугацаат 928.3 сая төгрөгийн зээлийн хүүд 323.2 сая төгрөгийн хүү тооцож нийт 1,251.5 сая төгрөгийг аймгийн аж ахуй нэгжийн давсан орлого, санхүүгийн дэмжлэгээс Сангийн яамнаас суутган тооцож төлүүлсэн ч тус зардлыг хэрхэн шийдвэрлэх талаар дээд шатны байгууллагуудаас шийдвэр гаргаагүй байна.

Сумдын инженерийн шугам сүлжээний ашиглалт үйл ажиллагааг шилжүүлсэнтэй холбоотой Алтай, Мянгад, Зэрэг сумдын Шим ус ОНӨААТҮГ-ын балансад бүртгэлтэй 2,979.9 сая төгрөгийн инженерийн шугам сүлжээний барилга байгууламж, тоног төхөөрөмжийг

балансаас балансад шилжүүлсэнтэй холбоотой үндсэн хөрөнгө, эздийн өмчийн дүнд нөлөө үзүүлж байна.

Бусад асуудлын хэсэг

Шим ус ОНӨААТҮГ нь 94 ажилтантайгаар цэвэр усны 49 км, бохир усны 45.3 км шугам сүлжээгээр 203 аж ахуй нэгж байгууллага, 172 орон сууцны 4260 айл өрх, ус түгээх ухаалаг 18 цэгээр дамжуулан гэр хорооллын 5018 айл өрхийг усаар ханган ажиллаж байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн хүлээх үүрэг, хариуцлага

Компанийн удирдлага санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Упсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 828,310,069 | 1,134,418,807 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 36,981,497 | 41,608,418 |
| 311 | Кассанд байгаа бэлэн мөнгө | 113,235 | 115,553 |
| 31110 | Төгрөг | 113,235 | 115,553 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 36,868,261 | 41,492,865 |
| 3121 | Төгрөг | 36,868,261 | 41,492,865 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 36,868,261 | 41,492,865 |
| 33 | АВЛАГА | 249,995,976 | 213,547,670 |
| 33401 | Дансны авлага /ТӨҮГ/ | 249,995,976 | 206,237,670 |
| 335 | Бусад авлага | - | 7,310,000 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 7,310,000 |
| 34 | УРДЧИЛГАА | 220,000 | |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 220,000 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 541,112,596 | 879,262,719 |
| 354 | Хангамжийн материал | 541,112,596 | 879,262,719 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 16,772,079 | 19,009,471 |
| 35420 | Аж ахуйн материал | 173,107,146 | 293,848,365 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 316,716,769 | 529,143,736 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,543,636 | 2,830,909 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 31,972,965 | 34,430,238 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 10,869,053,481 | 17,743,827,783 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 10,869,053,481 | 17,743,827,783 |
| 392 | Биет хөрөнгө | 10,869,053,481 | 17,734,272,783 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 5,253,585,535 | 8,507,848,031 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (460,044,509) | (1,148,063,599) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 503,091,828 | 659,583,868 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (166,175,161) | (291,905,444) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,696,869,687 | 6,030,817,132 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,113,851,732) | (1,183,285,354) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 14,694,000 | 19,396,273 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (13,091,067) | (14,093,023) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 5,153,974,900 | 5,153,974,900 |
| 393 | Биет бус хөрөнгө | - | 9,555,000 |
| 39301 | Програм хангамж | 9,050,000 | 19,970,000 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (9,050,000) | (10,415,000) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 11,697,363,550 | 18,878,246,590 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 961,547,129 | 1,302,255,566 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 33,203,320 | 1,302,255,566 |
| 413 | Өглөг | 33,203,320 | 1,302,255,566 |
| 4136 | Бусад өглөг | 33,203,320 | 1,302,255,566 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 12,234,414 |
| 41363 | Татварын өглөг /ТӨҮГ/ | 33,203,320 | 38,492,551 |
| 41366 | Дансны өглөг /ТӨҮГ/ | | 1,251,528,601 |
| 42 | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 928,343,809 | - |
| 422 | Урт хугацаат зээл | 928,343,809 | - |
| 4222 | Гадаад валют | 928,343,809 | - |
| 42230 | Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/ | 928,343,809 | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 10,735,816,420 | 17,575,991,024 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 10,735,816,420 | 17,575,991,024 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 10,737,419,275 | 17,845,254,479 |
| 51101 | Өмч: - төрийн | 10,086,961,840 | 10,086,961,840 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | 650,457,435 | 7,758,292,639 |

| | | | |
|------------|--|------------------------------|------------------------------|
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (699,363,442) | (967,024,042) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (699,363,442) | (1,026,600,491) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 59,576,449 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 697,760,587 | 697,760,587 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>11,697,363,550</u> | <u>18,878,246,590</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|---------------------------|--------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,976,020,404 | 2,797,338,924 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,976,020,404 | 2,797,338,924 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,976,020,404 | 2,797,338,924 |
| 120010 | Борлуулалтын орлого (цэвэр) /ОНӨҮГ/ | 1,976,020,404 | 2,797,338,924 |
| 120011 | Борлуулалтын өртөг /ОНӨҮГ/ | 1,543,086,111 | 2,064,405,915 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,727,113,971 | 2,479,970,038 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,727,113,971 | 2,479,970,038 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,727,113,971 | 2,479,970,038 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,727,113,971 | 2,479,970,038 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,727,113,971 | 2,479,970,038 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 184,027,860 | 257,792,437 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 184,027,860 | 257,792,437 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>248,906,434</u> | <u>59,576,449</u> |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>248,906,434</u> | <u>59,576,449</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|-----------------------------|-----------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>2,224,597,675</u> | <u>3,171,779,083</u> |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | <u>2,224,597,675</u> | <u>3,171,779,083</u> |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | <u>2,224,597,675</u> | <u>3,171,779,083</u> |
| 120009 | Бусад орлого | 67,130,088 | 202,357,247 |
| 120013 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ОНӨҮГ/ | 2,157,467,587 | 2,969,421,836 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>2,191,679,122</u> | <u>3,134,320,162</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | <u>2,191,679,122</u> | <u>3,134,320,162</u> |

| | | | |
|--------|---|----------------------|----------------------|
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,191,679,122 | 3,134,320,162 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 704,727,023 | 892,505,894 |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ОНӨҮГ/ | 704,727,023 | 892,505,894 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 203,978,497 | 243,304,132 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ОНӨҮГ/ | 203,978,497 | 243,304,132 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 259,458,486 | 405,088,583 |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ОНӨҮГ/ | 259,458,486 | 405,088,583 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 746,368,064 | 1,177,217,603 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 48,020,663 | 110,407,102 |
| 210410 | Бараа материал худалдан авахад төлсөн /ОНӨҮГ/ | 698,347,401 | 1,066,810,501 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 280,147,052 | 416,203,949 |
| 210816 | Татварын байгууллагад төлсөн /ОНӨҮГ/ | 246,582,092 | 266,432,787 |
| 210817 | Даатгалын төлбөрт төлсөн /ОНӨҮГ/ | 1,260,000 | 2,470,125 |
| 210818 | Бусад мөнгөн зарлага /ОНӨҮГ/ | 32,304,960 | 147,292,037 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 29,918,553 | 37,458,921 |
| 225101 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ОНӨҮГ/ | 222,500,000 | 32,802,000 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 29,918,553 | 4,656,920 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 7,062,944 | 36,981,497 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 36,981,497 | 41,608,417 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын сруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь эзэмшээний нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|-------------|---|
| C01 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 0 | 0 | 0 | | 0 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 0 | | 0 |
| C08 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 10,086,961,840 | 697,760,587 | -1,022,548,234 | 650,457,435 | 10,735,816,420 |
| D01 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 10,086,961,840 | 697,760,587 | -1,022,548,234 | 650,457,435 | 10,735,816,420 |

| | | | | | | |
|-----|---|-----------------------|--------------------|-----------------------|----------------------|----------------|
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | -4,052,257 | 7,107,835,203 | 7,103,782,946 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 10,086,961,840 | 697,760,587 | -1,026,600,491 | 7,758,292,638 | 0 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0 | 0 | 0 | | 0 |
| D07 | Галдаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 59,576,449 | | 59,576,449 |
| D09 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 10,086,961,840 | 697,760,587 | -967,024,042 | 7,758,292,638 | 17,417,260,185 |

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр

| № | Үзүүлэлт | 2021 оны Гүйцэтгэл | 2022 он | | Харьцуулалт | |
|---|--------------------------------------|--------------------|---------------|---------------|---------------|--------|
| | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| А | Үйлдвэрлэсэн: Цэвэр ус | 980,000 | 1,078,000 | 1,156,000 | 78,000 | 0.16 |
| | Түгээсэн: Бохир ус | 850,000 | 935,000 | 982,000 | 47,000 | 0.16 |
| | Нийт орлого : | 1,976,020,400 | 2,685,085,000 | 2,797,338,900 | 821,318,500 | 0.32 |
| | Үүнээс: Цэвэр борлуулалт | 1,870,060,700 | 2,446,335,000 | 2,119,077,400 | 249,016,700 | 0.24 |
| Б | Үйл ажиллагааны бусад орлого | 105,959,700 | 238,750,000 | 678,261,500 | 572,301,800 | 105.37 |
| | Нийт зардал | 1,727,114,000 | 2,664,117,000 | 2,737,762,700 | 1,010,648,700 | (0.01) |
| | Үүнээс: Удирдлагын зардал | 31,312,000 | 40,000,000 | 18,000,000 | (13,312,000) | (0.02) |
| Б | Татварын өмнөх ашиг | 248,906,400 | 20,968,000 | 59,576,200 | (189,330,200) | (1.21) |
| | Цэвэр ашиг / алдагдал / | - | - | - | - | (1.21) |
| | Төрийн өмчийн ногдол ашиг | - | - | - | - | - |
| | Борлуулалтын 1 төгрөгт ногдох зарлал | 1 | 1 | 1 | - | (0.25) |
| | Нийт авлага | 214,067,805 | - | 213,547,670 | (520,135) | 1.26 |
| | Нийт өглөг | 961,547,129 | - | 1,302,255,889 | 340,708,760 | 0.15 |
| | Богино хугацаат өр төлбөр | 33,203,320 | - | 1,302,255,566 | 1,269,052,246 | 0.15 |
| | Урт хугацаат өр төлбөр | 928,343,809 | - | | (928,343,809) | |
| | Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт | - | - | - | - | |

| | | | | | |
|--------------------------|-------------|---------------|-------------|-------------|--------|
| Нийт ажиллагсдын тоо | 80 | 108 | 97 | 17 | (0.01) |
| Нийт цалингийн сан | 797,526,400 | 1,198,908,100 | 978,181,000 | 180,654,600 | 0.05 |
| Нэг ажилтны дундаж цалин | 830,757 | 925,083 | 840,362 | 9,605 | 0.06 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шим-Ус ОНӨААТҮ газар нь *Ховд хотын хүн амын тав тухтай амьдрах, ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө аймаг орон нутгийн тогтвортой хөгжлийн бодлого, үзэл баримтлалыг хэрэгжүүлэн* “Ус хангамж, ариутгах татуурга болон бусад ажил үйлчилгээгээ стандартын дагуу чанарын өндөр түвшинд хийж, гүйцэтгэх” эрхэм зорилт дэвшүүлэн үйл ажиллагаа явуулж байна.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг

- ✓ Орон нутгийн өмчийн цэвэр, бохирын инженерийн шугам сүлжээ арчлалт, хамгаалалт, засвар үйлчилгээ,
- ✓ Албан байгууллага болон иргэдийн хэрэглээний цэвэр усыг нийлүүлж бохир усыг татан зайлуулах,
- ✓ Цэвэрлэх байгууламж, цэвэр усны станцын тогтмол үйл ажиллагааны горимын биелэлт, гүйцэтгэл
- ✓ Албан байгууллага болон иргэдийн цэвэр бохир ус, халаалтын сантехникийн засвар, үйлчилгээ
- ✓ Цэвэр усны хэрэглээ, бохир усны зайлуулалтын үйлчилгээний хураамж авалт
- ✓ Нийтийн халуун усны үйлчилгээ
- ✓ Байгууллагын бохир ус, хог тээвэрлэлт гэж тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорилт гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тайлант онд 15 ажил хийх төлөвлөгөө батлүүлж үүнээс 14 ажлыг 100.0 хувь, гүйцэтгэж санхүүгийн хүрэлцээгүй байдлаас үүдэлтэй цэвэр усны шугам шинээр тавих ажил хэрэгжээгүй 0 хувь, нийт 93.0 хувийн гүйцэтгэлтэй биелүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шүүд түслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

НААҮ-ний “Шим-ус”ОНӨААТҮГ – нь 1999.05.13-ны ИТХ-ын 29 дугаар тогтоолоор үүсгэн байгуулж 2013 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 89 дугаар тогтоолоор Дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлд Орон нутгийн өмчийн талаарх Иргэдийн төлөөлөгчдийн бүрэн эрх 77.4 “орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

Шим ус ОНӨААТҮГ-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг сард 0.72 мянган төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд

төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 3.7-д "...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна" гэсэн заалтай нийцэж байна

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдаж мөрдөгдсөн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шим ус ОНӨААТҮГ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар болсон 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шим ус ОНӨААТҮГ-ийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 361 тоот тушаалаар баталсан "Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7181.0 сая төгрөгөөр буюу 61 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|-----------------|-----------------|----------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 37.0 | 41.6 | 4.6 |
| Авлага | 249.9 | 213.6 | (36.3) |
| Урьдчилж гарсан зардал | 0.2 | - | (0.2) |
| Бараа материал | 541.1 | 879.3 | 338.2 |
| Үндсэн хөрөнгө | 10,869.1 | 17,734.2 | 6,865.1 |
| Биет бус хөрөнгө | - | 9.6 | 9.6 |
| Нийт хөрөнгө | 11,697.3 | 18,878.3 | 7,181.0 |
| Өр төлбөрийн дүн | 961.5 | 1,302.4 | 340.9 |
| Богино хугацаат өр төлбөр | 33.2 | 1,302.4 | 1,269.2 |
| Урт хугацаат өр төлбөр | 928.3 | - | (928.3) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 10,735.8 | 17,575.9 | 6,840.1 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 11,697.3 | 18,878.3 | 7,181.0 |

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Оны эцэст тус байгууллагын мөнгөн хөрөнгийн касс дахь бэлэн мөнгө 0.1 сая, банк дахь харилцах дансанд 41.5 сая нийт 41.6 сая төгрөг байна.
- ✓ Тайлант онд авлага 213.6 сая төгрөг болж 36.3 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь айл өрхийн цэвэр бохир усны авлага 73.8 сая төгрөгөөр буурч 44.4 сая төгрөг, байгууллагаас авах цэвэр бохир усны авлага 48.8 сая төгрөгөөр өмнөх оноос буурч 19.4 сая төгрөг, Хашаандаа сайхан амьдарцгаая төслийн бараа материалын авлага 53.0 сая төгрөг, Дархан ар-Шанд ХХК-иас авах тоолуурын авлага 28.9 сая төгрөгөөр тендерийн баталгааны авлага 7.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.
- ✓ Бараа материалын дансны үлдэгдэл 879.3 сая төгрөг болж 338.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд орчны бохирдол бууруулах төслийн хүрээнд гэр хорооллын айл өрхүүдэд цэвэр бохир усны шугам сүлжээ холбох ажлын тендер шалгаруулалтад оролцож сантехникийн сэлбэг хэрэгсэл 478.7 худалдан авч 111.5 сая төгрөгийн материал зарцуулж 367.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй, цахилгааны 138.0 сая төгрөгийн материал худалдан авч 312.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй, 29.3 сая төгрөгийн авто сэлбэг худалдан авч зарцуулж 17.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй дансдууд нөлөөлсөн байна.
- ✓ Үндсэн хөрөнгө 17,734.2 сая төгрөг болж 6,865.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 482 тоот шийдвэрээр цэвэр усны шугам 6040м, бохир усны шугам 1460м шугам сүлжээг 4,000.0 сая төгрөг, жаргалант сумын инженерийн шугам сүлжээ 300.0 сая төгрөг, ИТХ-ын даргын А/50 захирамжаар аймгийн ЗДТГ-аас 40.0 сая төгрөгийн балансын үнэтэй ковш, 7/11 тогтоолоор А/69 тоот захирамжаар 189.2 сая төгрөгийн цэвэр усны эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын хашаа, 7/15 дугаар тогтоолоор 36.8 сая төгрөгийн балансын үнэтэй 30.9 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй фургон машиныг Ховд сумын ЭМТ-өөс, аймгийн ИТХ-ын 8/04 дугаар тогтоолоор Алтай, Мянгад, Зэрэг сумдын Шим ус ОНӨҮГ-ын 2,979.9 сая төгрөгийн балансын үнэтэй 553.4 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг балансаас балансад тус тус шилжүүлсэн, өөрийн хөрөнгөөр 14.5 сая төгрөгийн Filder авто машин, Компьютер тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч тайлант хугацаанд 257.7 сая төгрөгийн элэгдлийн зардал байгуулсантай холбоотой байна.
- ✓ Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 1,302.4 сая төгрөг болж 1,269.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 1998 онд Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйг хөгжүүлэх төслийн хүрээнд төвлөрсөн усан хангамж, ариутгах татуургын системийг шинэчлэх, халуун усны үйлчилгээг сэргээн сайжруулах, гэр хороололд амьдрагчдын усан хангамжийг сайжруулах, хуурай хог хаягдлын асуудлыг шийдвэрлэх замаар хүн амын амьдралын нөхцөлийг сайжруулах зорилгоор олгосон урт хугацаат зээл, зээлийн хүү нийт 1251.5 сая төгрөгийг аймгийн ЗДТГ-ын аж ахуй нэгжийн орлогоос суутган тооцсонтой холбоотой урт хугацаат өр төлбөрийг 928.3 сая төгрөгөөр бууруулан богино хугацаат өр төлбөр данс руу шилжүүлж хүүгийн төлбөр 323.2 сая төгрөгийг богино хугацаат өр төлбөр дансанд бүртгэлээ.
- ✓ Засгийн газрын хувь оролцоо Эздийн өмчийн дансны үлдэгдэл 17,575.9 сая төгрөг болж 6,840.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь үндсэн хөрөнгийн өөрчлөлттэй холбоотой байна.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Шим ус ОНӨААТҮГ-ийн дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, дээд шатны байгууллагаар батлуулж, биелэлтийг ханган ажиллах үүрэгтэй.

ТУЗ-ийн 2022 оны 02 дугаар тогтоолоор Шим ус ОНӨААТҮГ-ийн 2022 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилготой түвшин, цалингийн санг баталсан бөгөөд тайлант оны нийт орлогыг 2,685.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 2,664.1 сая төгрөгөөр, цалингийн санг 1,198.9 сая төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр 2,797.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,737.7 сая төгрөгийн зардал гарган, 59.6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 2,797.3 сая төгрөг болж төлөвлөснөөс 112.4 сая төгрөг буюу 4.2 хувиар давсан байна. Орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр авч үзвэл айл өрх, төсөвт байгууллага, аж ахуйн нэгжээс 208.6 сая төгрөг, халуун усны орлого 41.2 сая, ухаалаг усан сангийн орлого 93.7 сая, засвар үйлчилгээний бусад орлого 35.3 сая төгрөг, орчны бохирдол бууруулах төслийн хүрээнд гэр хорооллын айл өрхүүдэд цэвэр бохир усны шугам сүлжээ холбох ажлын тендер шалгаруулалтад оролцож шалгарч 541.0 сая төгрөгийн санхүүжилт авсантай холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2737.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 73.6 сая төгрөг буюу 2.7 хувиар хэтэрсэн гүйцэтгэлтэй байна. Зардлын гүйцэтгэлийг нэр төрлөөр авч үзвэл цалин НДШ-д 1113.1 сая төгрөг зарцуулж 241.5 сая төгрөг, ариутгал халдваргүйжүүлэлт, 33.0 сая төгрөг, харуул хамгаалалтын зардал 4.6 сая төгрөг, конторын хангамжийн зардал, 19.7 сая төгрөг, хөдөлмөр хамгааллын зардлыг 20.4 сая төгрөг, даатгалын зардлыг 12.5 сая төгрөгөөр тус тус хэмнэж, цахилгаан дулааны хэрэглээ 15.4 сая төгрөг, түлш тээвэр шатахуун 15.7 сая төгрөг, засвар үйлчилгээний зардал 80.2 сая төгрөг, маркетинг борлуулалт, лабораторийн шинжилгээний зардал 21.7 сая төгрөг, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 43.2 сая төгрөг, татварын зардал 90.8 сая төгрөг, үйл ажиллагааны бус зардал 136.9 сая төгрөгөөр тус тус хэтэрч зарцуулсан байна.

Айлант онд цэвэр ашиг 59.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 38.6 сая төгрөгөөр илүү байгаа нь үйл ажиллагааны бус орлого, татаас санхүүжилтийн орлого нөлөөлсөн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд дулааны станцын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор С.Оюунжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Ховд дулааны станцын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 26 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр борлуулалтын орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэв

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн борлуулалтын орлогын 2797.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 41.9 сая төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2 - 15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлага, өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийг мэдээлж ажилласан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар түрээсийн орлогын 40 хувь, ХХОАТ суутган төсөвт төвлөрүүлээгүй засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй, бараа материалын тооллого хийж үлдэгдэл баталгаажуулаагүйтэй холбоотой зөрчлүүдэд төлбөрийн акт, зөвлөмж өгөгдсөнийг тайлант онд бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|--------------|----------|--------------|------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 10.3 | 1 | 10.3 | 100 |
| Зөвлөмж | 2 | 133.3 | 2 | 133.3 | 100 |
| Нийт дүн | 3 | 143.6 | 3 | 143.6 | 100 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Богино хугацаат зээлийн өрийг хэрхэн барагдуулах талаарх дээд шатны шийдвэрийн хэрэгжилтийг хянах үзэх шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2054.7 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 2054.7 сая төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- ✓ **Хууль тогтоомжтой холбоотой:** Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйг хөгжүүлэх төслийн хүрээнд төвлөрсөн усан хангамж, ариутгах татуургын системийг шинэчлэх, халуун усны үйлчилгээг сэргээн сайжруулах, гэр хороололд амьдрагчдын усан хангамжийг сайжруулах, хуурай хог хаягдлын асуудлыг шийдвэрлэх замаар хүн амын амьдралын нөхцөлийг сайжруулах зорилгоор 1998 онд олгосон урт хугацаат зээл, зээлийн хүү нийт 1251.5 сая төгрөгийг аймгийн ЗДТГ-ын аж ахуй нэгжийн орлогоос суутган тооцсонтой байхад зардлыг хэрхэн шийдвэрлэх талаар дээд шатны байгууллагуудаас шийдвэр гаргаагүй байгаа тул урт хугацаат өр төлбөрийг 928.3 сая төгрөгөөр бууруулж, богино хугацаат өр төлбөр данс руу бичилт хийгээгүй, хүүгийн төлбөр 323.2 сая төгрөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүйг аудитын явцад залруулан богино хугацаат өр төлбөр дансанд 1251.5 сая төгрөгөөр бүртгэж залруулга хийлээ.
- ✓ **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** аймгийн ИТХ-ын 8/04 тогтоолоор Зэрэг сумын ЗДТГ-ын балансад бүртгэлтэй 321.3 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 803.2 сая төгрөгийн балансын үнэтэй цэвэрлэх байгууламжийг данс бүртгэл тусгаагүй орхигдуулсныг Үндсэн хөрөнгийн барилга байгууламж дансанд бүртгэж залрууллаа. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна. .

Аудитаар нийт 193.9 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 193.9 сая төгрөгийн 4 зөвлөмж өгөгдлөө.

5.1. Зөвлөмж

5.1.1 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: 2021 онд VOLVO EW145B маркын дугуйт экскаваторыг аймгийн онцгой комиссын шийдвэрээр 100 сая төгрөгт багтаан шууд гэрээ байгуулах эрх олгосон ч 220.0 сая төгрөгөөр шууд худалдан авалт хийсэн байна. Үлдэгдэл санхүүжилт 2022 онд 100.0 сая төгрөгийн ХХХС-аас дэмжлэгээр авсан байна. Мөн цэвэрлэх байгууламжийн хашаа барих ажлын 2*4, 3*5 квадрат төмрийг 53.9 сая төгрөгөөр шууд худалдан авалт хийсэнтэй холбоотой 173.9 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 "шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар" МУЗГ-ийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2021 оны "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 124 дүгээр тогтоолын хавсралт, эрх үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааны хууль болон Засгийн газрын тогтоолыг баримтлан худалдан авалт хийж хэвших, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.

5.1.2 Зардлын данстай холбоотой

Илрүүлэлт 2. Төсөвт батлагдаагүй, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод журамд дэмжлэг үзүүлэхээр тусгаагүй, бакалаврын сургалтын төлбөрт тушаал шийдвэргүйгээр төсвөөс хөрөнгө зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тушаал шийдвэргүй төсвөөс хөрөнгө зарцуулахгүй байх, Хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээний заалтыг мөрдөх

5.1.3. Санхүүгийн тайлангийн үзүүлэлттэй холбоотой:

Илрүүлэлт 3. Сумдын инженерийн шугам сүлжээний ашиглалт үйл ажиллагааг шилжүүлсэнтэй холбоотой Алтай, Мянгад, Зэрэг сумдын Шим ус ӨНӨҮГ-ын балансад бүртгэлтэй 7.2 сая төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй, , Нийгмийн даатгалын тайлан, цалингийн тооцооны хүснэгт зөрүүтэй илэрхийлж, тайлагнасан ХХОАТ-ын, өглөг ҮЭ хорооны авлага тайлагнаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах " гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харилцагч байгууллагуудтай дахин тооцоо нийлж ажил гүйлгээг хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бүртгэж 2023 оны эхний хагас жилийн тайлангаар залруулах

5.1.4. Санхүүгийн тайлангийн үзүүлэлттэй холбоотой:

Илрүүлэлт 4. Байгууллагын төсвөөс албан хаагчдад спортын хувцас, Ховд лигт оролцсон тамирчдын хувцас худалдан авч унааны зардал олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4.хуулиар зөвшөөрөөгүй бусад, 8 дугаар зүйлийн 8.1"Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж төсвийн үргүй зардал гаргахгүй байх

6. АУДИТААР ИПЭРСЭН БУРУУ ИПЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|--|------------|---------|-----------------------------------|---------|--------------------------|-------|------------|---------|--------------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төлөгдсөн урт хугацаат өр төлбөрийг бууруулаагүй | 1.0 | 928.3 | - | - | 1.0 | 928.3 | 1.0 | 928.3 | - | - |
| хүүгийн төлбөрийг данс бүртгэлд тусгаагүй | 1.0 | 323.2 | 1.0 | 323.2 | | | 1.0 | 323.2 | | |
| Шилжиж ирсэн үндсэн хөрөнгө бүртгээгүй | 1.0 | 803.2 | 1.0 | 803.2 | | | 1.0 | 803.2 | | |
| Дүн | 3.0 | 2,054.7 | 2.0 | 1,126.4 | 1.0 | 928.3 | 3.0 | 2,054.7 | - | - |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая.төгрөг /

| Зөрчлийн товч утга | Үүнээс | | | | | |
|--|-------------|-------|---------------|-----|---------|-------|
| | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 2021 онд VOLVO EW145B маркын дугуйт экскаваторыг аймгийн онцгой комиссын шийдвэрээр 100 сая төгрөгт багтаан шууд гэрээ байгуулах эрх олгосон ч 220.0 сая төгрөгөөр шууд худалдан авалт хийсэн, Үлдэгдэл 100 сая төгрөгийг 2022 онд ХХХС-аас дэмжлэгээр авсан. Мөн цэвэрлэх байгууламжийн хашаа барих ажлын 2*4, 3*5 квадрат төмрийг 53.9 сая төгрөгөөр шууд худалдан авалт хийсэн. | 1 | 174.0 | | | 1 | 174.0 |
| Төсөвт батлагдаагүй, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод журамд дэмжлэг үзүүлэхээр тусгаагүй, бакалаврын сургалтын төлбөрт тушаал шийдвэргүйгээр төсвөөс хөрөнгө зарцуулсан | 1 | 3.5 | | | 1 | 3.5 |

| | | | | | | |
|---|----------|--------------|----------|----------|----------|---------------|
| Сумдын инженерийн шугам сүлжээний ашиглалт үйл ажиллагааг шилжүүлсэнтэй холбоотой Алтай, Мянгад, Зэрэг сумдын Шим ус ОНӨГ-ын балансад бүртгэлтэй 7.2 сая төгрөгийн бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй. Нийгмийн даатгалын тайлан, цалингийн тооцооны хүснэгт зөрүүтэй илэрхийлж, тайлагнасан ХХОАТ-ын, өглөг ҮЭ хорооны авлага тайлагнаагүй | 1 | 12.6 | | | 1 | 12.6 |
| Байгууллагын төсвөөс албан хаагчдад спортын хувцас, Ховд лигт оролцсон тамирчдын хувцас худалдан авч унааны зардал олгосон | 1 | 3.8 | | | 1 | 3.8 |
| Дүн | 4 | 193.9 | - | - | 4 | 193.90 |


АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

 С.ОЮУНЖАРГАЛ
6117123692
9086454